

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ



Д.УРАНТОГОС

**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
8 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

“А” ХУВИЛБАР

Хугацаа : 60 минут

Нийт: 20 оноо

Анги :

Сурагчийн нэр :

Эрхий дарам зай

Зураач Жамбад бага залуугаас эхлээд хижээл насыг хүртэл үзэж өнгөрүүлсэн амьдралд нь олон янзын захиалга, үүрэг, гуйлт тохиож байлаа. Зарим нь цай чанах зуур бүтээчихмээр, зарим нь зун намрын зургаан сард арайхийн бармаар янз янзын юм байж билээ. Тэр бүхнийг зурж, сийлж, зорж, зүлгэж урлан бүтээсээр өдий хүрчээ. Цай чанах зуур бүтээсэн юманд нь агт морь, атан тэмээний шан ч өгч байлаа. Зун намрын зургаан сард арай чүү багтаан хийсэнд нь соном хадаг төдийнхний харамж өгдөг хүн ч байлаа. Жамба зураач тэр бүхнийг ихийг нь их гэхгүй багыг нь бага гэхгүй авдаг байлаа. Харин энэ удаа хэзээ ч санаж бодож байгаагүй захиалгатай учирчээ. Захиалга нь, шан харамж нь ч ер бусын юм байлаа. Нэг цун буюу эрхий дарам зайд мянган заан эсвэл гурван зуун бурхан багтаан зурж Богд эзэн хаанд өргөн барих ээлжит сонин юм болгон авч ир гэж зураачид их эзний нэрээр лүндэн зарлиг буужээ. Хэрвээ тэр зарлигийг бүтээж чадахгүй бол нүгэл алдас болохоор барахгүй амь насанд нь халтай гэж тэрхүү аймшигт тушаалыг дамжуулж ирсэн хүн завсраас нь эрчийг нэмэн чангалж давхар сүрдүүлжээ. "Нэгэн цунд мянган заан" гэсэн үгийг эргэцүүлэн бодох ч шаардлагагүй тийм утгагүй шахам зүйл гэдгийг наад захын ухааны багахан бэлтэй хүн ч ойлгож байлаа. Богд эзнээс ийм лүндэн зарлиг буусныг сонссон хүн болгон зураачийг өрөвдөж, "Харганын ноос түүж эсгий хийх" гэгч болох нь ээ гэгцгээж байлаа. Тэр бүхэн Жамба зураачид падгүй хэрэг, түүний өмнөөс хэн ч тэр хэцүү ажлыг бүтээгээд өгөхгүй нь лавтай. Өөрөө л шийдэх учиртай. Тийнхүү хэдэн хоног бодол болон явлаа. Эрхий дарам зайд мянган заан байтугай нэг зааныг л арай ядан багтааж зурах юмдаа гэхээс өөр бодол толгойд орж ирсэнгүй. Богд эзний даалгавар гүйцэлдүүлэх хугацаа богино болохоор өдөр хоног бүрий түүнд үнэтэй байлаа. Өнгөрөх хоног болгон нь зураачийг гунигт төгсгөл рүү ойртуулна. Тийм сэтгэлийн хямрал дунд нэлээн олон хоног өнгөрөөн бодлоо. Зураач маань бийр, цаасаа гартаа барьсангүй. ... Хоног хугацаа нисэх мэт өнгөрсөөр л байлаа. Зураачийн сэтгэл шаналсаар л байлаа. Хошуу нутгийнхан нь ч, танил нөхөд нь ч цөм тус болохыг хичээнэ. Гэвч үнэхээр сэтгэшгүй, биелэшгүй юманд хариу олдсонгүй. Зураачийн түмэн ухаан, мянган арга ч тус болсонгүй. Тэгтэл хаврын нэгэн өдөр зураач гэрийнхээ гадна гиюүрэн сууж байхыг харсан гуйлгачин эр дэргэд нь очжээ.

1. Эхийн гол санааг олоод тайлбарлан бичээрэй. ᠒ оноо

- A. Богд эзэн хааны лүндэн зарлигийг биелүүлэх нь чухал
- B. Өөрийн алдаа, дутагдлыг бусдад харуулах нь ичгүүртэй.
- C. Ямар ч байсан эзэн дээдсийн зарлигийг биелүүлэх хэрэгтэй

D. Аливааг бүтээхэд арга ухааныг олох нь чухал байдаг

.....
.....
.....

2. Эхийн хэсгүүдийн зөв дарааллыг олоорой. 12 оноо

A. Зураач Жамба, хариу олдсонгүй, давхар дээлт, бүтээлийн санааг олов, бүтээл төрөв, Богд эзний лүндэн,

B. Зураач Жамба, Богд эзний лүндэн, давхар дээлт, бүтээлийн санааг олов, бүтээл төрөв, хариу олдсонгүй,

C. Зураач Жамба, Богд эзний лүндэн, хариу олдсонгүй, бүтээлийн санааг олов, бүтээл төрөв, давхар дээлт,

D. Зураач Жамба, Богд эзний лүндэн, хариу олдсонгүй, давхар дээлт, бүтээлийн санааг олов, бүтээл төрөв

3. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоод, засаж бичээрэй. 12 оноо

A. Сэрүүн салхи үе үе үлээх боловч дулаан бөгөөд ер бусын тайван, аятай ажээ.

B. Суман дэлтэй өндөр зээрд морь унасан Эрдэнэ эмээл дээрээ ялимгүй хэлтгий сууж, ямар нэгэн гүн бодолд дарагдана.

C. Саяхан хүүхдүүд байсан, одоо ингээд л гэрлэх болж байдаг. Цаг ч мөн хурдан юм даа гээд Итгэлт өөхөө цай хийж уув.

D. Өөдөөс харан сууж байгаа хүүхнийг зориуд инээж, чанга чанга ширтэж байв.

E. Чи битгий надад гомдоорой, би ч чамд тэр нэгэн цагт хязгааргүй сэтгэлтэй байсан минь үнэн

.....
.....
.....
.....

4. Хэлцийн утгыг тайлбарлаж, өгүүлбэр зохион бичнэ үү? 12 оноо

Барилдахаасаа таахалзах нь -

.....
.....
.....
.....

5. Оноосон нэрийн дүрмийн тайлбарлан бичнэ үү? 12 оноо

Төмөрөөр-

Дарханаас-



**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
8 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

“Б” ХУВИЛБАР

Хугацаа : 60 минут

Нийт- 20 оноо

Анги :

Сурагчийн нэр :

Өвөл

Би номын мөр хөөж, хот суурин газар анхны цасыг угтаж, сүүлчийн цасыг үдэх боллоо.

Энд анхны цас жигтэй түргэн хайлах юм. Өвөл гэсэн ондоо, хот газрын өвөл болно. Тэнгэр гэдэг цастай цонх шиг цэвцийн цайрч, нар гэдэг сонингоор халхалсан чийдэн шиг зузаан үүлэн цаана тэмдэг төдий сүүмийнэ. Унадаг дугуй, бүсгүйчүүдийн үзэсгэлэн намрын шувуудтай буцчихсан юм шиг гудамж талбайд үзэгдэх нь ховордоно. Өдөржин гадаа байдаг багачуул голцуу л гал тогооны өрөөнд хөгшин эмгэдийн хамт өнжинө. Шувуу буцаад, жигүүртэн ховордоод тэр үү тагтаа болжмор хоёрыг цонхоор ажиглах болов. Хааяа нэг тохиолдох нам гүм, цас мөс гялалзсан өдөр тагтаа сүрэглэн тэнгэрт гарч, элин халин сэтгэлийн чилээ гарган, инээж баясаж байх шиг харагдана. Тувт дулаан байранд бүгэн суусаар хамаг биед байшин барилгын үнэр нэвччихсэн юм шиг бодогдоно. Хөдөөнөөс ирсэн хүнээс жавар ханхлах сайхан санагдана.

Жихүүн салхи ганц нэгээр уйтгартай нь аргагүй исгэрч, цас манарган одно. Хаа нэг дайралдах малын мөр дулаан харагдана. Малын мөр олшрохоор сэтгэл онгойно. Удалгүй утаа үнэртэн, өвөлжөөний зүг цувсан малын зэрэг харагдаж нохой хуцна. /Д.Батбаяр/

1.Эхэд юуны тухай өгүүлсэн бэ? Тайлбарлан бичээрэй. 12 оноо

- A. Хөдөөний хүний тухай
- B. Номын мөр хөөсөн хүний тухай
- C. Жигүүртэй ховордсон тухай
- D. Хот газрын өвлийн тухай

.....

.....

.....

.....

2. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олж, засаж бичээрэй. 12 оноо

- A. Бурам амттай боловч буйгаар нь идэж болохгүй
- B. Үнэр ялдам агь гангыг эзэгнэхэн төрлөө би
- B. Найган гайхах цэцгийг намрын салхи үлээнэ.
- Г. Цаасан дээр мөртэй, цасан дээр нэртэй хүн шүү би.
- Д. Царайд нь улбар ягаан туяа тодрон, улам ч сайхан болов.

.....

.....

.....

.....

3.Хэлцийн утгыг тайлбарлан, өгүүлбэр зохион бичнэ үү? \2 оноо\

Ус ууж, өвс идсэн юм шиг-

.....
.....
.....
.....

4.Үгсийг утгаар зөв холбоод өгүүлбэр зохиогоорой. \2 оноо\

Сайхан , тараг

Бүрх, малгай

5. Дараах өгүүлбэрийн найруулгын алдааг засаж бичээрэй. \2 оноо\


Нар баруун хойноос гарахгүй бололтой.

.....
.....
.....
.....

6. Усны эргүүлэг буюу “Борзооны явдал” гол санааг , өөрийн үзэл бодолтойгоо уялдуулан 60-70 үгэнд багтаан бичээрэй \5 оноо\

.....
.....
.....
.....
.....
.....

7. Галигаас үндэсний бичигт буулгаарай. \5 оноо \



.....
.....
.....
.....
.....
.....

VIII АНГИЙН АНГИ ДЭВШИХ МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН ХИЧЭЭЛИЙН ШАЛГАЛТЫН ТҮЛХҮҮРҮҮД :

А ХУВИЛБАР

- 1.D. Аливааг бүтээхэд арга ухааныг олох нь чухал байдаг зөв сонгосон бол 2 оноо
2. D. Зураач Жамба, Богд эзний лүндэн, хариу олдсонгүй, давхар дээлт, бүтээлийн санааг олов, бүтээл төрөв зөв сонгосон бол 2 оноо
3. D. Өөдөөс харан сууж байгаа хүүхнийг зориуд инээж, чанга чанга ширтэж байв гэж зөв сонгосон бол 1 оноо, алдааг зассан бол 1 оноо
4. Онгиороо сагсуу зантай хүнийг хэлнэ гэж тайлбарласан бол 2 оноо
- 5.Эгшигт, заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эгшиг гээгдэхгүй гэж тайлбарласан бол 2 оноо, 1-ийг тайлбарлавал 1 оноо
6. Хариултыг бүрэн хариулсан бол 5 оноо, дөхүүлсэн бол 3 оноо
7. **Монгол бичгийн даалгавар үгийн тоо-10**
 - 0-1 алдвал 5 оноо
 - 2-4 алдвал 4 оноо
 - 5-7 алдвал 3 оноо
 - 8-9 алдвал 2 оноо
 - 10 алдвал 0 онооЁсыг бурхан дагана, ёрыг чөтгөр дагана, эвийг эртнээс эрдмийг эхнээс

Б ХУВИЛБАР

- 1.D. Хот газрын өвлийн тухай зөв сонгосон бол 1 оноо, тайлбарласан бол 1 оноо
2. Г. Цаасан дээр мөртэй, цасан дээр нэртэй хүн шүү би.зөв сонгосон бол 1 оноо, Цаасан дээр нэртэй, цасан дээр мөртэй хүн шүү засаж бичсэн бол 1 оноо
3. D. Маш туранхай хүнийг хэлнэ гэж тайлбарласан бол 1 оноо, хэлцээр өгүүлбэр зохиосон бол 1 оноо
4. Ээж сайхан тараг бүрсэн байна, Аав бүрх малгайгаа өмсөв гэж өгүүлбэр бол 2 оноо, 1 өгүүлбэр зохиосон бол 1 оноо
- 5.Нар баруун хойноос гарах бололтой гэж бичсэн бол 1 оноо
6. Хариултыг бүрэн хариулсан бол 5 оноо, дөхүүлсэн бол 3 оноо
7. **Монгол бичгийн даалгавар үгийн тоо-8**
 - 0-1 алдвал 5 оноо
 - 2-4 алдвал 3 оноо
 - 5-6 алдвал 2 оноо
 - 7 алдвал 1 оноо
 - 8 алдвал 0 онооНэрийг залуугаас, эрдмийг багаас, номыг эс сурваас номхоныг нь сур

